



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 398

Улаанбаатар хот

Г “Футур эволюцион ББСБ” ХХК-ийн 7
банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх
зарим тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож,
зарим тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.4, 14.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Футур эволюцион ББСБ” ХХК-ийн гадаад валютын арилжаа, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. “Футур эволюцион ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн зээл, төлбөрийн баталгаа гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2010 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

3. Холбогдох тэмдэглэгээг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд хийлгэж, шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2010 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Футур эволюцион ББСБ” ХХК /Роберто Ди Серио/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН